# Сумын Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр

## Жинст сумын Засаг даргын Тамгын газар

## 2023 оны жилийн эцэс

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Нэг: “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд: | | | | | | | |
| 1 | 1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлнэ. | 1.1.1. Сумын нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана. | 2021 - 2024 | | | Эрүүл мэндийн төвийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг 2023 онд 1 удаа тодотгон Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган бэлэн байдлыг сумын онцгой комисстой хамтран зохион байгуулан ажиллаж байна. 2023 онд тохиолдол бүртгэгдээгүй. Онцгой байдлын газрын Халдварын үеийн бэлэн байдал хариу арга хэмжээний үнэлгээнд 92,4 хувьтай үнэлэгдсэн байна.<br>Хавсралт : 2 зураг | 100% |
| 2 | | 1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед эрүүл мэндийн салбарын хэмжээний шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног | 2021 - 2024 | | | Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг 2023 онд 1 удаагын татан авалтаар тасралтгүй нэмэгдүүлж, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, бүтэн жилийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нөөцийг бүрдүүлнэ. | | | | | |
| 3 | | 1.1.3. Цахим орчин, албан байгууллага, багийн Засаг дарга нараар дамжуулан, иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх, сэрэмжлүүлэг мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна. | 2021 - 2024 | | | Коронавируст халдвар / КОВИД-19 /-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг зэрэг байгууллагуудын салбар дундын оролцоо бүхий багаар халдварын нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээг 1 удаа хийж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгон, хэрэгжилт, тайлан, мэдээг тухай бүрт хүргүүлж ажилласан. | 100% |
| 4 | | 1.1.4. Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, тусгаарлах болон эмчлэн тусгаарлах байруудын бэлэн байдлыг шуурхай хангаж эмч эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх арга барилд сургах ажлын байрны тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулж ур чадварыг нь дээшлүүлэн аюул эрсдлээс урьдчилан сэргийлж эрүүл мэндээр хохироохгүй байх арга хэмжээг авч ажиллана | 2021 - 2024 | | 85% | Сумын онцгой комисстой хамтран “Ковид-19” коронавирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг хийж, төлөвлөгөө гарган халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Хоёр: Хүний хөгжлийн бодлогын хүрээнд: | | | | | | | |
| 5 | 2.1. "Эрүүл иргэн - Ирээдүйн үнэт зүйл" | 2.1.1. Төсөвт албан байгууллагуудыг ажлын байран дээрээ артерийн даралт, биеийн жингээ хэмжих, эрүүл мэндээ хамгаалахад зориулсан тоног төхөөрөмжийг бий болгон ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ. | 2021 - 2024 | | 85% | Эрүүл мэндийн төвөөс төсөвт байгууллагууд дээр урьдчилан сэргийлэх үзлэг, оншилгоо, сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Сургалт, үзлэгт нийт 170 ажилтан, алба хаагч оролцсон . | 90% |
| 6 | | 2.1.2. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна. | 2021 - 2024 | | | Бадамлан асах жаргал эмийн сантай хамтран ажиллаж байна. Эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдалд, эмийн сангийн үйл ажиллагаанд нийт 1 удаа хяналт хийж ажилласан. | 100% |
| 7 | | 2.1.3. Иргэдийн зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулж, "Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | 2023 оны 12 дугаар сарын байдлаар артерийн гипертензи үзлэгт хамрагдах 1283 иргэнээс 1160 хамрагдаж 90,6% чихрийн шижингийн эрт илрүүлэгт хамрагдах 735 иргэнээс 722 хамрагдаж 98,2%, Хөх умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдах 152 иргэнээс 112 хамрагдаж 73,2% Хавдрын эрт илрүүлэх үзлэгийг Энх тунх эмнэлгийн эмч нартай хамтран 58 хүн хамруулж хавдрын 2 сэжигтэй тохиолдолыг илрүүлж 2-р шатлалд илгээсэн. Элэгний В-1 С-0 вирус илэрсэн 1 иргэн байгаа ба идэвхижил тодорхойлуулах шинжилгээнд хамруулхаар илгээсэн | 100% |
| 8 | | 2.1.4. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар | 2021 - 2024 | | | Орон нутгийн хүн амын шилжилт хөдөлгөөнийг үнэн зөв бүртгэж, явуулын болон өөр орон нутгаас оршин суугаа иргэдэд эрүүл мэндийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана. | | | | тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаң ажиллаж байна. | |
| 9 | | 2.1.5. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 2021 - 2024 | | | Ёс зүйн багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ёс зүйгээ дээдэлсэн хамт олон уриатай үйл ажиллагаагаа явуулж байна өргөдөл гомдол гараагүй Ёс зүйн дүрмийг мэдээллийн самбартаа тогтмол байршуулан ёс зүйн сургалтыг ёс зүйн баг 2 удаа нэг удаагийн сургалтанд 32 хүн хамрагдсан. | 100% |
| 10 | | 2.1.6. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж шүдний өвчлөлийг бууруулж үр дүнг тооцно. | 2021 - 2024 | | | 2023 онд сургуулийн болон цэцэрлэгийн насны 103 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэг хийж 52 хүүхдэд шүд цоорох эмгэтэй байна.<br><br>Хавсралт : 4 зураг | 100% |
| 11 | | 2.1.7. Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдийн зөв зохистой хоололтыг дэмжих сургалт сурталчилгааг тогтмол хийж хүн амын дундах хоол хүнсний далд чихэр тослогыг бууруулан эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг багасгах замаар илүүдэл жингээс сэргийлэх, бөөр зүрх судасны өвчлөлийг бууруулна. | 2021 - 2024 | | | Мөн зөв зохистой хооллолтын ач тус хүний бие эрүүл мэндэд ямар эерэг сайн нөлөөтэй талаар сургалт мэдээ мэдээллийг ерөнхий боловсролын сурагчдад болон дотуур байрны сурагчид тогооч нарыг хамруулсан сургалтыг хүүхдийн их эмч Э.Болортуяатай хамтран хоёр удаа зохион байгуулсан. | 100% |
| 12 | 2.2. Эрүүл, идэвхитэй амьдралын хэв маягийг сурталчлах, | 2.2.1. Иргэдэд бие бялдараа хөгжүүлэх спорт, спортын дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг эрүүл, зөв амьдралын хэв маягийг | 2021 - 2024 | | | “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээний хүрээнд Жинст сумын бүх төрийн албан хаагчид, болон ахмадын холбоо, хувийн хэвшил, аж ахуй нэгж, ард иргэд, ерөнхий боловсролын сурагчид, нэгдэж ажлын байрны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл аж төрөх ёс, нийтийн биеийн тамирыг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн түвшинд дэмжин хөгжүүлнэ. | хэвшүүлж, эерэг хандлагатай болгох нөлөөллийн үйл ажиллагааг бодлогоор дэмжин, төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшиж зөв зохистой хооллолтыг дэмжиж аянд идэвхтэй оролцож байна. Аяны хүрээнд нарны алхалтыг долоо хоногийн 5 дахь өдөр болгон алхаж идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжиж байна. Мөн зөв зохистой хооллолтын ач тус хүний бие эрүүл мэндэд ямар эерэг сайн нөлөөтэй талаар сургалт мэдээ мэдээллийг ерөнхий боловсролын сурагчдад болон дотуур байрны сурагчид тогооч нарыг хамруулсан сургалтыг хүүхдийн их эмч Э.Болортуяатай хамтран гурван удаа зохион байгуулсан. Эрүүл идэвхтэй амьдрах эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор нийт ард төрийн албан хаагчид болон ард иргэдийн дунд гар бөмбөг болон буухиа тэмцээнүүдийг тус тус зохион байгуулж явуулсан. Энэ жилдээ эрүүл жиндээ аяны хүрээнд сумын төрийн албан хаагчид жингээ хасах 1 сарын хугацаатай челленж зарлан дасгал хөдөлгөөн болон зөв зохистой хооллолтоор жингээ хасаж өрсөлдсөн. 3кг-7.8кг хооронд жин хассан үр дүнтэй байна. | |
| 13 | | 2.2.2. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заалны ашиглалтыг сайжруулж, нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг хөгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | | | Спорт заалаа түшиглэн иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, эрүүл чийрэг идэвхитэй хөдөлгөөнийг тогтмолжуулах зорилгоор фитнесс танхимтай болсон. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд иргэд байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажлын 5 өдөрт төрийн албан хаагчид /2 цаг 18-20/ бусад үед ард иргэдэд нээлттэйгээр тоглолтын хуваарь гарган хуваарийн дагуу үйлчилж байна. Мөн сонгон дугуйлангууд хичээлэн ажлын 4 өдөрт сонгоны цаг гарган үйлчилж байна. Нийт спорт заалаар үйлчлүүлсэн иргэдий тоо давхардсан тоогоор 2650 гаруй иргэд спорт заалаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчлүүдсэн байна. | |
| 14 | | 2.2.3. Спорт заалыг түшиглэн иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх эрүүл чийрэг идэвхитэй хөдөлгөөнийг тогтмолжуулах зорилгоор фитнесс танхимтай болно. | 2021 - 2024 | 2021 оны төсвийн хөрөнгөөр 7.000,000 | | Спорт заалаа түшиглэн иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, эрүүл чийрэг идэвхитэй хөдөлгөөнийг тогтмолжуулах зорилгоор фитнесс танхимтай болсон. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд иргэд байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажлын 5 өдөрт төрийн албан хаагчид /2 цаг 18-20/ бусад үед ард иргэдэд нээлттэйгээр тоглолтын хуваарь гарган хуваарийн дагуу үйлчилж байна. Мөн сонгон дугуйлангууд хичээлэн ажлын 4 өдөрт сонгоны цаг гарган үйлчилж байна. Нийт спорт заалаар үйлчлүүлсэн иргэдий тоо давхардсан тоогоор 2650 гаруй иргэд спорт заалаар үйлчлүүдсэн байна. 2021 онд төсвийн хөрөнгөөр 7 сая төгрөгийн фитннессийн тоног төхөөрөмж худалдан авч өрөө тохижуулж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100% |
| 15 | 2.3. Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ. | 2.3.1. Боловсролын байгууллагуудын хүүхдийн тоог нэмэгдүүлж хамран сургалтыг 80 хувьд хүргэнэ. | 2021 - 2024 | хөрөнгө шаардахгүй | | Хамран сургалт 100 хувь, сургууль завсардалт байхгүй. | 100% |
| 16 | | 2.3.2. Орон нутагт дутагдалтай байгаа захиалгат мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна. | 2021 - 2024 | хөрөнгө шаардахгүй | | Арга хэмжээний хүрээнд нийгмийн ажилтан, түүх нийгмийн ухааны багшаар Э.Энхцэцэг, бага ангийн багшийн 4-р курсын оюутан Б.Оюундарь нарыг дадлагажигч багшаар ажиллуулж байна. | 100% |
| 17 | | 2.3.3. Уралдаан тэмцээнд амжилт гаргах | 2021 - 2024 | хөрөнгө шаардахгүй | | Багш Д.Гантөмөрийн удирдсан нисэх загварын дугуйлангийн сурагч Б.Шинэбаяр аймгийн олимпиадад 1 дүгээр байр, ААШ U10, U12 насны волейболын тэмцээнд багш Д.Эрдмаагийн дасгалжуулсан баг 1, 2, 3 дугаар байр эзэлсэн амжилт гаргав. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт : 3 зураг | |
| 18 | | 2.3.4. Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж шагнаж урамшуулна. | 2021 - 2024 | | | Чадварлаг багш 3 зорилт, 21 ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна. Зорилт -1. Багш бэлтгэх сургалтыг чанаржуулах чиглэлийн хүрээнд: • Хууль, эрх зүйн сургалт зохион байгуулсан. • Сургалтын шилдэг хөтөлбөр шалгаруулах уралдаан зохион байгуулсан • Ур чадварын уралдаан зохион байгуулсан. • Сургалтын шилдэг хөтөлбөр шалгаруулсан. Зорилт-2 Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлийн хүрээнд:<br>• БШУГ-ын мэргэжилтэнгээс зөвлөн туслах үйл ажиллагаа авч байна.<br>• “Интерактив хичээл” бэлтгэх арга зүйн сургалт явуулсан.<br>• “Google Forms”, “Liveworksheets” апп ашиглан цахим даалгаврын сан бүрдүүлсэн.<br>• “Мини олимпиад”, “Алтан хонх” танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулсан.<br>• Ном гарын авлага хийж бэлтгэх, дасгал ажлын дэвтэр бэлтгэсэн.<br>• Цахим хичээл, даалгаврын сан хамгийн их ашиглаж байгаа багш, анги хамт олныг тодруулсан.<br>Зорилт 3. Багшийн ажлын нөхцөл, цалин хөлс эзэлсэн багш, сурагчдыг шагнаж урамшуулах наж урамшуулсан.<br>• Багш, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргасан.<br>• Туршлага судлах аялал зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан.<br>• Багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулсан.<br>• Багш мэргэжлийн зэрэг шинээр авах болон зэргээ ахиулахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Багш бүр “Багшийн амжилт” бүтээлийн сантай болох, шилдэг, тэргүүний багш, ажилтныг тодруулж шагнах, аймаг, улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд 1-3 дугаар эзэлсэн багшийг “Багшаа алдаршуулъя” цахим сурталчилгаа хийсэн. | |
| 19 | | 2.3.5. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрд ээлтэй болгож багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | | 90% | 4-5 сард Бэлтгэл бүлгийн буюу 5 настай хүүхдүүдийг СӨБ-д бүрэн хамруулж сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг хийсэн.<br>- Хаврын улиралд СӨБ-д хамрагдаагүй хүүхдүүдэд зуны цэцэрлэг буюу хувилбарт сургалтаар хамран сургахаар ажиллаж байна. | 100% |
| 20 | | 2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, цахим, сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ цахим сургалтын тоног төхөөрөмжөөр хангагдсан кабинеттэй болно. | 2021 - 2024 | Багшид хичээл зохион байгуулсан цагийн хөлс 30 цаг187.500 Сургалтын материалын зардал 60.000 | | Цахим, сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлэх зорилгоор хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан гаргаж батлуулсан, төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн. Сур Цахим сургалтын тоног төхөөрөмжөөр хангагдсан мэдээлэл зүйн кабинеттай болон MAXHUB ухаалаг дэлгэцтэй сургалтын өрөөтэй. | 100% |
| 21 | | 2.3.7. Хөгжмийн кабинетийг тохижуулж хагжмийн зэмсгээр | 2021 - 2024 | | | Төсвийн хэмнэлтийн хуулийн заалтыг хэрэгжүүлэх шаардлагын улмаас хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхгүй байна. Одоогоор хөгжмийн | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангагдана. | | | | дугуйланг Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэгээс хөгжмийн зэмсэг түрээслэн хичээллүүлж байна. | |
| 22 | 2.4. Иргэдийн нийгмийн баталгааг хангах. | 2.4.1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана. | 2021 - 2024 | хөрөнгө шаардахгүй | | 2022 онд 337 даатгуулагч хамруулан 16721.1 мянган төгрөг, 2023 онд 272 даатгуулагч хамруулан 19005.0 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна. | 100% |
| 23 | | 2.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | 5,0 сая төгрөг | | Сумын хэмжээнд нийт 63 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас 57 иргэн хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлэх боломжгүй асаргаатай 6 иргэн байна. 2021 онд 2 хөгжлийн бэрхшээлтэй аймгийн ХХҮГ-аас санхүүгийн дэмжлэг авч ажлын байраар хангагдсан. Б.Төмөрхуяг-3.0 сая, Э.Чойжил-2,0 сая төгрөгөөр тус тус дэмжигдэж 2023 онд эргэн төлөлтийг бүрэн барагдуулсан. | 100% |
| 24 | | 2.4.3. Ажилтай орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж 100-аас доошгүй иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдана. | 2021 - 2024 | 20,0 сая төгрөг | | Энэ онд ногоон ажлын байр хөтөлбөр үйл ажиллагаа, орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажил, төрийн болон хувийн хэвшилд нийт 62 иргэнийг ажилд зуучилж, хөдөлмөрийн зах зээлийн EJob програмд шивж бүртгэлжүүлсэн. Байнгын ажлын байр-17, түр ажлын байр 45 гарсан байна. | 100% |
| 25 | | 2.4.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 5 зорилт 12 арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажилласан. Төлөвлөгөөний биелэлт-90% | 90% |
| 26 | | 2.4.5. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2021 - 2024 | 10.0 сая төгрөг | | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуй эрхлэгчдэд хөдөлмөр эрхлэх чиглэлээр бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөөг 25 иргэнд өгч ажилласан. 2023 онд 2 ахмад настанд аймгийн ХХҮГ-аас тус бүр 5,0 сая | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож ажлын байрыг дэмжин ажилласан. /Д.Цэрэнпилжээ, Ж.Хоролгарав нарт/ | |
| 27 | | 2.4.6. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж хүний хөгжил, хамгааллыг сайжруулна. | 2021 - 2024 | Санхүүжилтгүй | 90% | Аймгийн ЗБХЗХГ-аас "Амар тайван гэр бүл" өдөрлөгийг зохион байгуулж явуулсан. Өдөрлөгөөр ЕБС-ийн сурагчдын дунд Үе тэнийн дээрэлхэлт, сайн дурын ажилзэсэг сэдвээр сургалт явуулсан. Гэр бүлийн модул сургалтын ЭМТ-ийн сургалтын танхимд явуулсан. Соёлын төвд бүх нийт иргэдэд мэдээлэл хүргэж, Эзэнгүй хоймор киног үзүүллээ. Хамтдаа шийдье сургаллтын хөдөөгийн 4 багт ГБХЗХГ-ын мэргэжилтнүүдийн хамт зохион байгуулж явууллаа. | 100% |
| 28 | | 2.4.7. Иргэдэд эрүүл аж төрөх дадал хэвшилд сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулна. | 2021 - 2024 | ЭМТ-ийн сургалтын зардал | 85% | Эмэгтэйчүүдийн дунд эрүүл жиндээ бооцоот уралдаан 2 дахь удаагаа явуулж байна. 1-р ээлжинд ЕБС-ийн багш ажилчид хамрагдлаа. 2-р ээлжинд бизнес эрхлэгч, төрийн албан хаагчид хамрагдаж байна. Энэ жилдээ эрүүл жиндээ сургалтыг иргэдэд тогтмол явуулж байна. | 90% |
| 29 | | 2.4.8. Ахмад өндөр настангуудын чөлөөлт цагаа өнгөрүүлэх, үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулах байртай болгож "Ахмадаа ачилъя" хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Сумын Ахмадын хороо сар бүр нийгийн идэвхи оролцоог дэмжин төрөл бүрийн уралдаан тэмцээн явуулж байна. Нумт харвааны баг тамирчид аймаг болон бүсийн чанартай тэмцээнд 7 удаа оролцож, Бөмбөгөр сумын 100 жилийн ойд 3-р байр, говийн сумдын бүсийн тэмцээнд 2-р байр эзэллээ. Ахмадын биеийн тамрыг дэмжих сарын аяны хүрээнд Шугаман бүжиг аймагт 2-р байр эзэлсэн. 7 хоног бүрийн Бямба гарагт спорт зааланд софт волейбол тоглож байна. Нумт харвааны зурхай, ширээний теннис, дартс зэрэг спортын төрлүүдийг хөгжүүлэхэд хэрэгсэлтэй болсон. Нийгмийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтнууд, ТББ-ынхан хамтран 8 удаагийн сургалт, зохион байгуулж давхардсан тоогоор 258 хүнг хамрагдсан байна. Софт, ширээний теннис, шагайн наадгай, дартс, шатар, даам, оюуны спорт тоглоом 51 удаагийн тэмцээн явуулж, ахмадууд 94% хамрагдсан байна. 2023.12.13-ны өдөр Суралцъя, хөгжье, оролцъё хамтдаа уриан доор зохион байгуулсан хүүхдийн чуулганы арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.<br><br>Хавсралт : 2 зураг | |
| 30 | 2.5. Соёлын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өсвөр үе залуучуудад сурталчлан таниулах, соёлын | 2.5.1. Сумын нийт ард иргэдийн дунд соёл урлаг, спортын нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулна. | 2021 - 2024 | хөрөнгө шаардахгүй | | Нутгийн яруу найрагч М.Цэрэнтогтохын шүлгийг хэн сайн унших вэ,Жинст сумын унаган хүү МУСТА хөгжмийн зохиолч Пунцагдансангийн Буянжаргалын зохиолын “дууг хэн сайн дуулах вэ” дууны тэмцээн зохион.“СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР” аяны хүрээнд “Бүжиглэх урлаг’’ тоглолт мөн Соёлын биет бус өвлөн уламжлагчдын дунд “Урлагын тоглолт ’’ зохион байгуулсан. | 100% |
| 31 | | 2.5.2. Соёлын биет ба биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ард иргэдэд сурталчилан таниулна. | 2021 - 2024 | | | Соёлын биет бус өвлөн уламжлагч Уламжилалт хос гар урлал ай савд Д.Түшинтулга, уламжилалт шагай харваа Х.Баттогтох, Монгол Хөөмэй Ц.Бат-аргамжаа,Үндэсний хөгжим С.Маам, Монгол цагаан идээ Г.Одончимэг нарын таван өвлөн уламжлагчийг шинээр бүртгэн анкетжуулан бүртгэлдээ авлаа. Соёлын биет бус өвлөн уламжлагч нийт 15 өвлөн уламжлагч байдаг .”Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд нийт өвлөн уламжлагчдын бүртгэл анкетыг шинэчилж бүртгэлжүүлэн бүсчилсэн сургалтанд хамруулсан. Соёлын бүтээлч сар буюу Монгол бахархалын өдрийг тохиолдуулан Таван багийн дунд зохион явуулсан “Монгол | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | салбарын хүний нөөцийг чадавхижуулах. | | | | | шагайн наадгай" шагайн тэмцээнд "Морь уралдуулах, шагай няслах, шагай шүүрэх "тэмцээнийг аврага малчдын дунд ЗДТГазартай хамтран зохион явуулсан. .Нийлбэр оноогоор "Хөнөг"баг 1-р байр,Уубулан 2-р байр,Хүйс 3-р байранд орж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР" аяны хүрээнд "БҮЖИГЛЭХ УРЛАГ'' тоглолт мөн Соёлын биет бус өвлөн уламжлагчдын дунд "УРЛАГ-ын тоглолт зохион явуулсан. Сумын түүх соёлын үл хөдлөх дурсгалт газарт нүд үзэн үзлэг тооллого хийх ажлыг Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батгэрэл даргаар ахлуулан 2 чиглэлд маршрут зураглалын дагуу явж 2 өдрийн турш тоолж бүртгэн гурвалсан гэрээ, фото зурагжуулалт хийж нийт 441км замыг туулж шатахууны зардлыг Соёлын төвийн шатахууны зардлаас шийдвэрлүүлж ажиллалаа.<br>1 дүгээр чиглэлд 7-н түүхэн дурсгалт газруудаар 186км зам; 2 дугаар чиглэлд 9-н түүхэн дурсгалт газруудаар 255км зам; Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газарууд. Үүнд:<br>1. Бодь овоо<br>2. Бүлээний өврийн сүг зураг<br>3. Засмалын цулгуй хөшөө<br>4. Уубулангийн цулгуй хөшөө<br>5. Цагаан тээгийн цулгуй хөшөө<br>6. Бөө хүрэнгийн цулгуй хөшөө<br>7. Мааньтын цохио<br>8. Дашгай хадны сүг зураг<br>9. Бунхны овоо<br>10. Уушгийн арын цулгуй хөшөө гэх 16 ТСҮХДГ-ыг ойр нутаглах малчидтай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээг байгуулж хамгаалтанд авсан. | |
| 32 | | 2.5.3. Урлаг соёлын чанар хүртээмжийг нэмэгдүүлж ажиллана. | 2021 - 2024 | | | Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйланд нийт 66 хүүхэд бүртэгүүлж 7 хонгийн Пүрэв,Баасан,Бямба,Ням гаригуудад тогтмол хичээллэж байна. Бүжгийн дугуйландаа Баллет,Монгол бүжиг, болон Европын цэнгээнт, Латин амирек бүжгүүдийг анхан шатнаас 66 хүүхдэд заан сургаж, мөн морин хуур, уртын дууны дугуйлан 22 хүүхэд суралцаж байна | 100% |
| 33 | | 2.5.4. Иргэдийн ном унших дадал хэвшлийг нэмэгдүүлж сумын номын сангийн үйл ажиллагааг сайжруулна. | 2021 - 2024 | 324,000 мян төгрөг | | Манай номын сан нь нийт 5307ширхэг номтой LUB4 цахим программд 100%шивэлтэнд орж шинээр 246 уншигч бүртгүүлж байнгын 203 ирэгсэд нийт 449 үйлчлүүлэгчидэд 512 номоор үйлчилсэн байна. Жинст нийтийн номын сан" нээж цахим номын сантэй болсоноор нийт уншигчид 1420 гаруй болж уншигчидын тоо нэмэгдсэн байна. Нутгийн яруу найрагч М.Цэрэнтогтохын "шүлгийн түүвэр" ном 324 000 төгрөгний үнэ бүхий 3-ширхэг номоор фондын баяжилт хийсэн. | 100% |
| 34 | | 2.5.5. Соёл урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тэдний ур чадварыг дээшлүүлнэ. | 2021 - 2024 | | | "Соёлын ажилтаныг чадавхжуулах сургалт , Соёлын сэргэлт-2023,Соёлын бүтээлч сар "аяны хүрээнд СУИС-ийн Соёлын сургуультай хамтран зохион байгуулсан номын санчдын чадавхжуулах сургалт,Хөгжмийн багш,Бүжгийн багш, Өвийн ажилтан,нярав нягтлан дарга нарын сургалтанд бүрэн хамрагдсан. | 100% |
| 35 | | 2.5.6. Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж Соёлын өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэн, | 2021 - 2024 | | | Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл зэрэг давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгааны улмаас соёлын өвд учирсан хохирлыг бууруулах, авран хамгаалах зэрэг сургалтыг ТСҮХДГ-ыг хариуцагч нартаа хийж гарын авлага боршуур тараасан. Соёлын биет | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | баяжуулан хөгжүүлж буй соёлын биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ. | | | | бус өвлөн уламжлагч нийт 15 өвлөн уламжлагч байдаг .”Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд нийт өвлөн уламжлагчдын бүртгэл анкетыг шинэчилж бүртгэлжүүлэн бүсчилсэн сургалтанд хамруулсан. ТСҮХДГ-ыг гэрээгээр хариуцагч 16 –н малчин өрхүүдэд урамжуулал болгож гарын бэлэг соёлын төвөөр үнэ төлбөргүй үйлчилүүлэх эрхийн бичгээр шагнаж урамшууллаа. | |
| 36 | | 2.5.7. Хоёр жилд 1 удаа соёл урлагийн өдрүүдийг суманд зохион байгуулж ардын авъяастнуудыг нийтэд сурталчилж, алдаршуулна. | 2021 - 2024 | | | “Бүжиглэх урлаг’’ тоглолт мөн Соёлын биет бус өвлөн уламжлагчдын дунд “Урлагын тоглолт ’’ зохион явуулсан. Эрдэнэт сүргийн эзэд – 1000 чуулганд оролцож Уртын дуу, Ардын богино дуу, Харилцаа дуу, Домог, шог хошин яриа, элэглэл онигоо, Ардын бүжиг бий биелгээ, Ардын хөгжим, Исгэрээ, тагнай ташилт, хөөмий, хоолойн лимбэ /өгүүлэхийн эрхтний шүтэлцээт урлаг/ Аман аялгуу, цол мялаалга, аялгуут үгс, аялгуут үлгэр /аман уламжлалын илэрхийлэл/ Ерөөл магтаал Хөдөлмөр зан үйлийн холбогдолтой уриа дуудлага зэрэг нийт 11 төрлөөр авьяас билгээ уралдуулан оролцсон. | 100% |
| 37 | | 2.5.8. Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг хөдөөд чиглүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж хувцас хэрэглэлээр хангана. | 2021 - 2024 | | | хөдөөд чиглүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж хувцас хэрэгсэлтэй болоогүй. | 50% |
| 38 | 2.6. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр | 2.6.1. Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно. | 2021 - 2024 | | 90% | Гэр бүлийнболовсрол олгох 3 удаагийн сургалтыг 2 сэдвээр явуулж, 157 хүн хамрагдсан. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай “Хамтдаа шийдье” гэр айлчилал сургалтыг ажлын хэсэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжил, хамгааллыг сайжруулна. | | | | | гарган зохион байгууллаа. | |
| 39 | | 2.6.2. “Иргэний андгай өргөх” танхимтай болж шинээр гэрлэгсэд болон шинээр иргэний үнэмлэх гардаж буй иргэдэд хүндэтгэл үзүүлэх, гэр бүлд чиглэсэн сургалт сурталчилгаа явуулах. | 2021 - 2024 | санхүүжил тгүй | | Шинээр гэр бүл болсон, иргэний үнэмлэх авсан иргэдэд иргэний үнэмлэх, гэрлэлтийн гэрчилгээг албан ёсоор гардуулан өгч хэвшсэн. | 70% |
| 40 | | 2.6.3. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | санхүүжил тгүй | 95% | Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийг Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж байна. Хөнгөлттэй нөхцлөөр их дээд сургуульд 1 оюутан суралцаж байна. Төрийн байгууллагуудад орон нутгаас 2 хүн шинээр ажилд томилогдсон байна. Санхүүжигдсэн хөтөлбөр байхгүй. | 100% |
| 41 | | 2.6.4. Хүүхдийн хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана. | 2021 - 2024 | санхүүжил тгүй | | Сумын нийт өрхийн 73% нь малчин, мал бүхий өрх байна. Хүүхдийг хөдөлмөрт сургах, монгол уламжлалт аргаар өсгөхөд давуу тал болж байгаа юм. Хөдөлмөр зуслан ажиллуулах нөхцөл, санхүү тусгагдаагүй. Өвгөнжаргалант зусланд амрахаар 5 хүүхэд бүртгүүлсэн байна. | 50% |
| 42 | | 2.6.5. Угийн бичиг хөтлөлтийг үргэлжлүүлж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна. | 2021 - 2024 | | 80% | Угийн бичиг хөтлөх сургалт арга зүй, нөлөөллийн ажлыг 2022 онд сумын хэмжээнд 10 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 800 орчим иргэн хамрагдсан. Үүний үр дүнд айл өрхүүд угийн бичиг бичиж эхэлсэн ба 2022 оны 11 сард тайлан үзэсгэлэн гаргаж 38 овог буюу ойролцоогоор 400 орчим өрх угийн бичгээ танилцуулсан. 2023 онд өмнөх онд бичиж эхэлсэн угийн бичгээ үргэлжлүүлэн бичиж байна. | 90% |
| 43 | | 2.6.6. Сум орныхоо нэр | 2021 - 2024 | 1.0сая | 100% | Сум орон нутгийнхаа нэрийг гаргаж урамтай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүндийг аймаг, улсад гаргаж байгаа залуучуудыг дэмжиж ажиллах, шагнаж урамшуулна. | | төгрөг | | сайн барилдаж байгаа хүйс 2 дугаар багийн харъяат сумын манлай заан Б.Бат-Эрдэнэд 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 44 | | 2.6.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумын эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, үнийн өсөлтийг тогтвортой байлгана. | 2021 - 2024 | 56.0 сая | 90% | Сумын "Бадамлан асах жаргал" ХХК-ны эмийн эрэлтийн сангаас хагас жилийн байдлаар 218 нэр төрлийн 56 сая төгрөгний эм, эмнэлгийн худалдан авч ард иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна хянгалт шалгалтын явцад гарсан зөрчилгүй. Хяналт шалгалтын 3 удаа зохион байгуулаад байна. Одоогоор эмийн нөөцийн хангалт 100%-тай байна. | 100% |
| 45 | | 2.6.8. Сумын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж ажиллана. | 2021 - 2024 | | 90% | Хамтарсан багийн төлөвлөгөөний биелэлт 94,2% тай биелэгдсэн. Сумдын бүсийн сургалтанд 100% хамрагдсан. Хамтарсан багийн ур чадварын тэмцээнд 2-р байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 300.000 төгрөгөөр дэмжигдсэн. Кейс дээр ажилласан зардал 552,000 төгрөгийн нэхэмжилж авсан. Аймгийн ГБХЗХГ-аас 2 удаа хамтарсан багт хяналт үнэлгээ хийж, арга зүйн зөвлөгөө авсан. | 100% |
| 46 | | 2.6.9. Иргэдийн бичиг баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бичиг баримтын үзлэг явуулах. | 2021 - 2024 | | 95% | Бичиг баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зөрчилтэй иргэдийн зөрчлийг арилгах зорилгоор 2023 оны 10дүгээр сарын01-с 2023 оны 11дүгээр сарын 30-ны хооронд багуудын хурал, цахим сүлжээ, иргэдтэй утасаар ярьж Багийн засаг дарга нартай хамтран бичиг баримтын үзлэг явууллаа . 491өрхийн 2170 иргэн хамрагдснаас 41 иргэн хаяж гээгдүүлэх, 25-45 насны сунгалт хэтрэх гэмтээх зэрэг зөрчилтэй байна. 26 иргэний зөрчлийг арилгасан.О У-н шилжилт хөдөлгөөний цахим бүртгэл төслөөс зоридтот | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүлгийн 4 иргэний үнэмлэхний төлбөрийг төлж гэрчилгээ олгосон байна | |
| 47 | | 2.6.10. Сумын хүүхдийн зөвлөлийн ажлыг эрчимжүүлнэ. | 2021 - 2024 | | 80% | Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлыг эрчимжүүлж Хүүхдээ сонсох өдрийг сар бүр зохион байгуулж хүүхдүүдийнхээ санал хүсэлтийг шийдвэрлэж 6 төрлийн бүтээлч ажлыг хийсэн. | 95% |
| 3. Гурав.Эдийн засгийн бодлого | | | | | | | |
| 48 | 3.1. Санхүү эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарах. | 3.1.1. Татварын хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтэд хяналт тавих, улс орон нутгийн төсвийн орлогыг татварын нэр төрөл бүрээр жигд хангаж биелүүлнэ. | 2021 - 2024 | | 90% | Улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөө 5 сарын 31-ны байдлаар нийт Аж ахуй нэгжийн орлогын албан татварт 950.0 мянган төгрөг, агаар бохирдлын төлбөр 610,5 мянган төгрөг төсөвт орсон.<br>Орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөө нь 5 сарын 31-ны байдлаар 76200,0 мянган төгрөг орохоос 86969,0 мянган төгрөг орж 114,1 хувиар биелэсэн байна. Орон нутгийн төсөвт орох 11 төрлийн татварын орлогоос 9 төрлийн орлого нь 100-аас дээш хувиар биелэсэн. Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөний хуваарийг тавихдаа ан агнасны тэмдэгтийн хураамж 10000,0 мянган төгрөгийн орлогыг сар бүрийн хуваарь дээр тавьж өгсөн нь биелэх боломжгүй байна. Газрын төлбөрийн орлого тасарсан шалтгаан нь тус суманд Ингэний фермер байгуулах зорилгоор 40 га газар Тамгын газрын нэр дээр олгосон. Энэ газрыг авсан аж ахуй нэгж нь газрын төлбөрөө төлөхгүй үйл ажиллагаа эхлээгүй ямар ч санхүү төсөв байхгүй гэсэн тайлбар хэлээд газрын төлбөрөө төлөхгүй байгаа нь хүндрэл үүсгэж байна. | 100% |
| 49 | | 3.1.2. Татвар төлөгчдийн | 2021 - 2024 | | | Галт зэвсгийн судалгаан дээр ажиллаж нэр | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгэл мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг бүрэн хамруулна. | | | | давхардсан, харъяалал андуурагдсан, шилжсэн, зарсан зэрэг 9 галт зэвсэг эзэмшигчийн хасалтыг хийлгэхээр аймгийн Цагдаагийн хэлтэсд хүргүүлсэн болно.<br><br>Зам Тээврийн Хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 03р сарын 03ны өдрийн А/57/48 тоот тушаал, Аймгийн Засаг Даргын 2023 оны 03-р сарын 27 ны өдрийн А/157 тоот захирамжийг тус тус үндэслэн Сумын Засаг даргын 2023 оны 04 -р сарын 21-ны өдрийн А/54 тоот захирамжаар Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг томилж 2023 оны 04-р сарын 01-нээс 2023 оны 04-р сарын 25 ныг хүртэлх хугацаанд сумын хэмжээнд тээврийн хэрэгслийн тооллогын ажлыг зохион байгуулж ажиллалаа. Манай сумын хэмжээнд сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт ороогүй, татвар төлөөгүй 223 тээврийн хэрэгсэл уг тооллогод хамрагдахаас 222 тээврийн хэрэгсэл хамрагдсан.<br><br>Сумын цагдаатай хамтран 2 иргэний галт зэвсгийг илрүүлж цагдаад бүртгүүлэн албан татварыг төлүүлсэн. Мөн хил дээр машин барьж орлого олсон 3 иргэний ибаримтыг бүртгэж 150.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаар ажил гүйцэтгэсэн 2 иргэнээс 1800.0 мянган төгрөгийг төсөвт оруулсан. | |
| 50 | | 3.1.3. Мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хэрэглээг иргэдэд сурталчлан таниулж, | 2021 - 2024 | хөрөнгө шаардахгүй | | Сумд бүртгэлтэй ААН 22, Хоршоо 7 байна. 2024.01.01 ээс шинэ тайлангийн системтэй болж байгаатай холбоотой 22 ААН-ийн 7 хоршооны бүртгэл тохиргоог шинэчлэн хийж баталгаажуулан хоршоонд нээлтийн тайлан хүсэлт илгээн шивж ажилласан. Он гараад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | тайланг 100% шивүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ил тод байдал бүрэн цахимжсан | |
| 51 | | 3.1.4. Байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж, ажилчдыг чадавхижуулан стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана. | 2021 - 2024 | | 90% | Хөдөө аж ахуй тасаг, Бичиг хэргийн ажилтан, Төсөв төрийн сангийн мэргэжилтэн, Татварын байцаагч, Улсын бүртгэгч, Байгаль орчины хяналтын улсын байцаагч нарт компьютер техник хэрэгсэлээр бүрэн хангасан. | 100% |
| 52 | | 3.1.5. Төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан хяналт тавина. | 2021 - 2024 | Санхүүжилтгүй | 85% | Төсөвт байгууллагуудын эд хөрөнгийн тооллого хийгдсэн тухай сумын өмч хамгаалах зөвлөл тайланг авч хянан актлах хөрөнгийн жагсаалтаар гарган сумын ИТХ-аар орулж зохих шийдвэрийг гаргуулан ажиллаж байна. | 90% |
